

ТАВАНТОЛГОЙ-ЦОГТЦЭЦИЙ ӨРТӨӨ ХООРОНДЫН ХОЛБОХ 21 КМ ТӨМӨР
ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ, ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР
ЗАМЫН САЛБАР ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2024 оны 11 сарын 15 -ны өдөр

Дугаар. 2024/18

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Өмнөговь аймгийн "Тавантолгой-Цогтцэций өртөө хоорондын холбох 21 км төмөр замын суурь бүтэц, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын салбар зам"-ыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн 98 дугаар тушаалаар байгуулагдсан 8 хүний бүрэлдэхүүнтэй 21 км төмөр замын суурь бүтэц, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын салбар замыг ашиглалтад оруулах комисс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1553 тоот албан бичгийг үндэслэж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны байранд ажиллав.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ: **Засгийн газрын 2019.07.24-ний 304 дүгээр тогтоол; Засгийн газрын 2020.09.23-ны 113 дугаар тогтоол;**

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: **зураг төслийн шифр дугааруудыг жагсаалтаар хавсаргав;**

2.3. Захиалагч: **"Тавантолгой төмөр зам" ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **000180806;**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, Б блок, 11 давхар, холбоо барих утас: 77777727, цахим хаяг: info@tz.mn;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: **"Бодь интернэшнл" ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011013143**, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар **СБУ 2/66-2021**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс товер, 3-р давхар, холбоо барих утас: /11/315144, цахим хаяг: info@bodigroup.mn;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: **жагсаалтаар хавсаргав;**

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: **зураг төсөл зохиогч байгууллагуудын жагсаалтыг хавсаргав;**

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: **"Тавантолгой төмөр зам" ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **000180806;**

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, Б блок, 11 давхар, холбоо барих утас: 77777727, цахим хаяг: info@tz.mn;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Хэвийн;**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү "Тавантолгой-Цогтцэций өртөө хоорондын холбох 21 км төмөр замын суурь бүтэц, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын салбар зам"-ын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а). барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 8 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 8 хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. "Тавантолгой-Цогтцэций өртөө хоорондын холбох 21 км төмөр замын суурь бүтэц, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын салбар зам"-ын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Комиссын дарга:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалт газрын дарга

Комиссын нарийн бичгийн дарга:

Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын Төмөр замын дохиолол, холбооны хяналт хариуцсан шинжээч, Улсын ахлах байцаагч



Д.ГАНТУЛГА

Д.БАТХҮҮ